

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн 7411 дүгээрт бүртгэв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 10/25

Дархан-Уул аймаг

ҮНЭ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйлийн 26.2, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалт, Эрчим хүчний зохицуулах хорооны 504 дугаар тогтоол, Шарын гол сумын “Түвшин элч хараа” ХХК -ийн 2025 оны 9-р сарын 23-ны өдрийн 12-р тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дархан-уул аймгийн Шарын гол сумын “Түвшин элч хараа” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан тарифыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Түвшин элч хараа” ХХК -ийн захирал /Д.Мөнхбат /-д үүрэг болгосугай.

3. Дархан-Уул аймгийн Зохицуулах зөвлөлийн 2025 оны 9-р сарын 11-ний өдрийн 09/25 тоот тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /Ч.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ч.БАТЖАРГАЛ

ГИШҮҮН
ГИШҮҮН

Б.ОЮУНТУЯА
Л.БААСАНХАНД

*Дархан-Уул аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
10/25 дугаар тогтоолын хавсралт*

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН “ТҮВШИН ЭЛЧ
ХАРАА” ХХК-ийн ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын “Түвшин элч хараа” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний төлбөр тооцох тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамаарч дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын эзэлхүүнээр тооцох халаалт		Төг/м³	2950
2	Төсөвт байгууллага хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	42613
		Тогтмол	Төг/м³	1858,5
3	Аж ахуйн нэгж хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	42613
		Тогтмол	Төг/м3	1858,5
4	Айл өрхийн халаалт		Төг/м³	1400

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 7412 дугаарт бүртгэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар А/271

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.12, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар /Х.Итгэлт/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 154 дүгээр тушаалын 13 дугаар хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/99 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны
өдрийн А/271 дүгээр тушаалын хавсралт*

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХ, БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь иргэн, хуулийн этгээдийн худалдан авсан болон түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх эрх болон бүртгэл хөтлөх, дугаар олгох, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх /цаашид “хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох” гэх/-той холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох үйл ажиллагаанд үнэн зөв, шуурхай, ил тод, хууль тогтоомжийг сахин мөрдөх зарчмыг баримтална.

1.3.Энэхүү журмыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/, суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, өмчлөгч, түрээслэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.4.Хөдлөх бүрэлдэхүүн хилээр нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох ажилтан, иргэн, хуулийн этгээд нь Олон улсын төмөр замын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, стандарт, Монгол Улсын хил, гаалийн байгууллагын холбогдох эрх зүйн акт, хилийн төмөр замын өртөөний технологийн горим, энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.5.Энэхүү журамд хэрэглэх нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.6.Монгол Улсын хилийн төмөр замын өртөө нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон хил, гаалийн үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

1.7.Монгол Улсын хилээр нэвтэрсэн илчит тэргийг илгээхдээ тухайн суурь бүтэц эзэмшигч байгууллагын зүтгүүрийн инженер, техникийн ажилтан зүтгүүр магадлагааны актыг бүрдүүлснийг үндэслэн хөдөлгөөнд оролцуулна.

1.8.Тухайн хөдлөх бүрэлдэхүүнд Монгол Улсын хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, стандартын дагуу дугаар, гэрчилгээ авах, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх, засвар үйлчилгээнд тогтсон хугацаанд оруулах нь хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч эзэмшигч иргэн,

хуулийн этгээдийн үүрэг байна.

1.9.Онцгой байдлын үед шуурхай нэвтрүүлэх шаардлагатай /аврах, сэргээн босгох, гал унтраах галт тэрэг, бүтээн байгуулалттай холбоотой зайлшгүй шаардлагаар нойтон түрээсээр ашиглах зам, засварын машин механизм г.м/ хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэ журам хамаарахгүй.

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.хөдлөх бүрэлдэхүүний дагалдах баримт бичиг нь Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, тогтоомж, үндэсний стандартад заасан шаардлагыг хангасан байх;

2.1.2.хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн байдлыг тодорхойлсон баримт бичиг /гэрчилгээ/-тэй байх;

2.1.3.Монгол Улсад ашиглах хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын хугацаа нь үндэсний стандартаар тогтоосон хугацааны 1/3 /гуравны нэгээс/ хэтрэхгүй байна. Уг хугацаанаас хэтрэхгүй ашигласан хөдлөх бүрэлдэхүүнийг оруулж ирэхдээ эрх бүхий байгууллагаар засвар, оношилгоо хийлгэсэн байх, мөн техникийн бүрэн бүтэн байдал, хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага нь бүрдүүлсэн байна;

2.1.4.худалдан авч байгаа болон түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүний хатуу дугаартай цутгамал эд ангийн насжилт нь вагоны ашиглагдсан хугацаанаас ихгүй байна;

2.1.5.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хөдлөх бүрэлдэхүүн нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад үйлдвэрлэгдсэн байна.

2.2.Монгол Улсын хилээр шинээр оруулан ирж төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, шаардлага, дугаарлалт, тэмдэг, тэмдэглэгээ нь энэхүү журамд заасан баримт бичгийн шаардлагыг хангасан байна. Мөн тухайн улсын нутаг дэвсгэрт худалдан авах болон түрээслэх хөдлөх бүрэлдэхүүнд хийсэн техникийн үзлэг, акт дүгнэлтийг ирүүлсэн байна.

2.3.Хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь Гаалийн тухай хуульд заасны дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.4.Монгол Улсын төмөр замын тээвэрт түрээсээр ашиглагдах хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн хугацаа нь стандартад заасан дунд засварын хугацаанаас хэтрэхгүй байна.

2.5.Хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нь засварын байгууллагыг сонгох эрхтэй ба эрх бүхий байгууллагаар засвар, үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд төмөр замын тээврийн байгууллага хооронд харилцан хүлээн зөвшөөрч, тээвэрлэлтэд ашиглана.

2.6.Төрийн захиргааны байгууллага нь жил бүрийн эхэнд худалдан авах, түрээслэх хөдлөх бүрэлдэхүүний эрэлт хэрэгцээ, суурь бүтцүүдийн багтаамж, галт тэрэг урсгалын тооцоолол, засварын баазын хүчин чадалд үндэслэн төмөр замын тээврийн байгууллагуудтай хамтран Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжит хөдлөх бүрэлдэхүүний төрөл, тоог тодорхойлно.

2.7.Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.6-т заасныг хэрэгжүүлэхдээ иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг он, цагийн дарааллаар ил тод, нээлттэй бүртгэж, мэдээлнэ.

ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

3.1.Монгол Улсад ашиглах зорилгоор худалдан авч буй хөдлөх бүрэлдэхүүнийг захиалан үйлдвэрлүүлэхээс өмнө үйлдвэрлэгчийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл, хийц, зураг төсөл, техникийн баримт бичгийг урьдчилан төрийн захиргааны байгууллагад ирүүлж техникийн нөхцөлийн дүгнэлт гаргуулна.

3.2.Иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүнийг нэвтрүүлэхдээ дараах баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үүнд:

3.2.1.хөдлөх бүрэлдэхүүн шинээр худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн албан хүсэлт;

3.2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

3.2.3.хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, бүдүүвч, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, ашиглалтын заавар, гэрэл зураг, ашиглах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг;

3.2.4.хөдлөх бүрэлдэхүүнд засвар, оношилгоо үйлчилгээ хийгдсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг, техникийн байдлын талаарх дүгнэлт;

3.2.5.худалдан авах болон түрээслэхтэй холбоотой гэрээний хуулбар, түүний баталгаат орчуулга;

3.2.6.хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хариуцах холбогдох инженерийн мэдээлэл, лавлагаа;

3.2.7.хилээр нэвтрэх нийт хөдлөх бүрэлдэхүүний томъёолсон уртаар бүрэн багтах хэмжээний өөрийн эзэмшлийн салбар замтай байх эсхүл салбар зам эзэмшигч байгууллагатай хамтран ажиллах гэрээ /

нэг салбар зам дээр давхар гэрээ хийхгүй байх/;

3.2.8.тээвэрлэлтийн урьдчилсан захиалга /илгээх өртөө, хүрэх өртөө, ачааны төрөл, тоо хэмжээ жилээр/;

3.2.9.өөрийн эзэмшлийн засвар үйлчилгээний газрын холбогдох баримт бичиг эсхүл эрх бүхий байгууллагатай байгуулсан засварын гэрээ.

3.3.Төрийн захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, холбогдох мэдээллийг үндэслэн хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг томилон ажиллуулна.

3.4.Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагааг тухайн төмөр замын тээврийн байгууллага, хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч, түрээслэгчтэй харилцан зөвшилцөн зохион байгуулна.

3.5.Энэхүү журмын 3.3-т заасан дүгнэлтийг өөрийн эзэмшлийн болон гэрээт салбар замд гаргах тохиолдолд төмөр замын тээврийн байгууллага нь Олон Улсын вагон эдэлгээний дүрэм¹ заасны дагуу бүрэн үзлэгийг хийж хүсэлт гаргагчийн замд байршуулах ажлыг зохион байгуулна.

3.6.Энэхүү журмын 3.3-т заасан дүгнэлт нь хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтэд ашиглах, эсхүл тээвэрлэлтэд ашиглахаас татгалзах үндэслэл болно.

3.7.Энэхүү журмын 2.5 дахь заалтын дагуу түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүн нь хугацаат засварт орж Монгол Улсын хилээр нэвтрэхэд энэхүү журмын 3.2, 3.3 дахь заалтыг мөрдлөг болгоно.

3.8.Ажлын хэсэг нь Монгол Улсын хилийн өртөө, эсхүл хүсэлт гаргагчийн өөрийн эзэмшлийн болон гэрээт салбар замд ажиллана.

3.9.Ажлын хэсгийн ажиллах зардлыг тухайн хүсэлт гаргач хариуцана.

ДӨРӨВ.МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРЭХ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ

4.1.Хөдлөх бүрэлдэхүүний өмчлөх, эзэмших эрх болон бүртгэл хөтлөх, дугаар олгох, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

¹ Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ОСЖД)-аас баталсан Олон Улсын вагон эдэлгээний дүрэм

4.2.Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 3.3-т заасан дүгнэлт, шийдвэрийг үндэслэн импортоор оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүнд үндэсний стандартын дагуу дугаар, өмчлөгч, эзэмшигчийн код, хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ олгоно.

4.3.Хилээр хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсад түрээсээр ашиглах зорилгоор оруулж ирсэн тохиолдолд түрээслэгчийн код шинээр олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.4.Энэхүү журмын 3.1-т заасан хөдлөх бүрэлдэхүүнд урьдчилан дугаар авахад техникийн нөхцөлийн дүгнэлт, худалдах, худалдан авах гэрээ, сорилт туршилтыг бүрэн хийж баталгаажуулсан баримт бичиг, үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ, вагон үйлдвэрлэх үеийн фото зураг, акт болон бусад баримт бичгийг үндэслэн 6 сар хүртэлх хугацаанд олгож болно.

4.5.Түрээсийн хөдлөх бүрэлдэхүүний гэрээний хугацаа дуусгавар болох, хугацаат засварт орохоор хилээр гарах, дунд засварт ороод хилээр буцаж орж ирэх, хөдлөх бүрэлдэхүүнийг давхар түрээслэх, түрээсийн хугацаа дуусч хилээр гарах тохиолдолд төрийн захиргааны байгууллагад болон төмөр замын тээврийн байгууллагад заавал мэдэгдэнэ.

4.6.Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээг бохирдуулсан, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд албан хүсэлт болон холбогдох материалыг төрийн захиргааны байгууллагад ирүүлж гэрчилгээг нөхөн олгоно.

4.7.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдлөх бүрэлдэхүүнийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд шийдвэр гаргасан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нөхөх болон сольж олгоно.

4.8.Монгол Улсад ашиглагдаж байгаа хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл шилжих тохиолдолд шилжүүлж буй өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ, биет байдлаар хүлээлцсэн акт болон бусад бичиг баримтыг үндэслэн мэдээллийн нэгдсэн санд өөрчлөлт оруулж, гэрчилгээг шинээр олгоно.

4.9.Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын нормт хугацаа дууссан, ашиглах боломжгүй тухай техникийн сорилт, оношлогоо хийх итгэмжлэгдсэн байгууллагын дүгнэлт гарсан, өмчлөгч, эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл мэдээлэл, дугаарыг нэгдсэн сангаас хасч, уг дугаарыг дахин ашиглахгүй.

4.10.Хөдлөх бүрэлдэхүүний улсын бүртгэлийн дугаар, өмчлөгч, эзэмшигчийн код, хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ шинээр авах тухай хүсэлт гаргахдаа энэхүү журмын 3.1, 3.2, 4.5-т заасан баримтыг ирүүлнэ.

ТАВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1.Төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага тус тусын чиг үүргийн хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

5.2.Төмөр замын тээврийн байгууллага болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь ашиглагдаж байгаа болон нөөцөд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын тайлан, судалгааг хагас, бүтэн жилээр гарган, төрийн захиргааны байгууллагад ирүүлж, тус байгууллага нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавина.

5.3.Төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага нь энэ журамд зааснаас өөр үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бусад баримт бичгийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

5.4.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар А/279

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-100 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо”-г хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 8 дугаар хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын
15-ны өдрийн А/279 дүгээр тушаалын хавсралт*

ИНД - 100 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

А Бүлэг - Ерөнхий зүйл

100.1. Зорилго

(а) Энэ дүрмээр иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (цаашид “SMS” гэх)-г бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахад тавигдах шаардлагыг тогтооно.

100.1(А). Хамрах хүрээ

(а) Энэ дүрэм нь Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын Хавсралт 19-ийн дагуу иргэний нисэхийн холбогдох дүрмээр SMS-ийг хэрэгжүүлэхийг шаардсан Үйл ажиллагаа эрхлэгч байгууллага (цаашид “Байгууллага” гэх)-д хамаарна.

100.2. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

100.3. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

(а) Энэ дүрэмд хамаарах байгууллага нь явуулахаар төлөвлөж байгаа, эсхүл гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны төрөл, цар хүрээндээ тохируулан дараах 4 хэсэг, 12 элементийг багтаасан SMS-ийг бүрдүүлсэн, хэрэгжүүлсэн, хадгалалтыг хангасан байна:

- (1) аюулгүй байдлын бодлого, зорилт, нөөц:
 - (i) удирдлагын амлалт;
 - (ii) аюулгүй байдлын хариуцлага болон үүрэг;
 - (iii) аюулгүй байдал хариуцсан ажилтны томилгоо;
 - (iv) онцгой нөхцөлийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний зохицуулалт;
 - (v) SMS-ийн баримт бичиг;
- (2) аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага:
 - (i) аюулыг таньж тогтоох;
 - (ii) аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах;
- (3) аюулгүй байдлын баталгаажуулалт:
 - (i) аюулгүй байдлын гүйцэтгэлийн хяналт болон хэмжилт;
 - (ii) өөрчлөлтийн удирдлага;
 - (iii) SMS-ийн байнгын сайжруулалт.
- (4) аюулгүй байдлын сурталчилгаа:
 - (i) сургалт болон боловсрол;

(ii) аюулгүй байдлын мэдээлэл солилцоо.

(b) [Хүчингүй болгосон]

(c) [Хүчингүй болгосон]

В Бүлэг – Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны бүрдэл

100.5. Аюулгүй байдлын бодлого, зорилт, нөөц

(a) Удирдлагын амлалт:

(1) байгууллага нь олон улсын болон үндэсний хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн дараах шаардлагыг хангасан аюулгүй байдлын бодлогыг тодорхойлсон байна:

(i) аюулгүй байдлын эерэг соёлыг сурталчлах ажиллагааг багтаасан, удирдлагын аюулгүй байдлын амлалтыг тусгасан;

(ii) аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх тухай мэдэгдлийг багтаасан;

(iii) аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах журмыг багтаасан;

(iv) байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хүлээн зөвшөөрөх боломжгүй зан үйл, үйлдлийн төрлийг тодорхойлж, хуулийн дагуу арга хэмжээ оногдуулах, эсхүл оногдуулахгүй байх нөхцөлийг тодорхойлсон;

(v) тухайн байгууллагын Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан;

(vi) тухайн байгууллагын бүх түвшинд ил тод харагдах, ойлгомжтой хэлбэрээр мэдээлэгдсэн;

(vii) тухайн байгууллагад хамааралтай бөгөөд тохирсон хэвээр байгааг бататгах зорилгоор тодорхой хугацаанд дахин хянаж, үнэлдэг байх;

(2) байгууллага нь аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх дараах шаардлагыг хангасан аюулгүй байдлын зорилтыг тодорхойлсон байна:

(i) энэ дүрмийн 100.9(a)(1)-т заасан аюулгүй байдлын гүйцэтгэлийг тодорхойлж, түүнийг хянах болон хэмжих зорилтыг тусгасан;

(ii) тухайн байгууллагын SMS-ийн нийт үр нөлөөг хадгалах, байнга сайжруулах амлалтыг тусгасан;

(iii) тухайн байгууллагын бүх түвшинд мэдээлэгдсэн;

(iv) тухайн байгууллагад хамааралтай бөгөөд тохирсон хэвээр байгааг бататгах зорилгоор тодорхой хугацаанд дахин хянаж, үнэлдэг байх.

(b) Аюулгүй байдлын хариуцлага болон үүрэг:

(1) байгууллага нь дараах үүрэгтэй:

(i) бусад үүрэг хариуцлагаас үл хамааран тухайн байгууллагыг төлөөлөн SMS-ийг үр дүнтэй бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хадгалах үүрэг бүхий хариуцлага хүлээх Гүйцэтгэх захирлыг томилох;

(ii) байгууллагын удирдлагын түвшинд аюулгүй байдлын үндсэн хариуцагчийг оролцуулан, байгууллагын хэмжээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхой заах;

(iii) бусад үүрэг хариуцлагаас үл хамааран байгууллагын аюулгүй байдлын гүйцэтгэлтэй холбоотой удирдах ажилтнууд болон ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох;

(iv) тухайн байгууллагын хүрээнд аюулгүй байдлын эрх, үүрэг хариуцлагыг баримтжуулах, харилцан мэдээлэх;

(v) аюулгүй байдлын эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшнийг тогтоох шийдвэр гаргах эрх мэдэл бүхий удирдлагын түвшнийг тодорхойлох.

(с) Аюулгүй байдал хариуцсан ажилтны томилгоо:

(1) байгууллага нь SMS-ийн хэрэгжүүлэлт болон хадгалалтыг хариуцсан аюулгүй байдлын удирдах ажилтныг томилсон байна. Байгууллагын үйл ажиллагааны төрөл болон цар хүрээнээс хамааран, SMS-ийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хадгалах үүргийг бие даан гүйцэтгэх аюулгүй байдлын удирдах ажилтанд тавих шаардлагыг бүрэн хангасан нэг этгээдийг, эсхүл аливаа ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх нөхцөл хангасан тохиолдолд хэд хэдэн этгээдийг бусад ажил үүрэгтэй хамтатган хариуцуулахаар томилж болно.

(d) Онцгой нөхцөлийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний зохицуулалт:

(1) байгууллага нь агаарын хөлгийн осол, зөрчил болон бусад нисэхийн онцгой нөхцөлийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд тухайн төлөвлөгөө нь бүтээгдэхүүн болон үйлчилгээгээр хангаж байгаа бусад байгууллагуудын онцгой нөхцөлийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй харилцан уялдаатай зохицуулагдсан болохыг бататгана.

(e) SMS-ийн баримт бичиг:

(1) байгууллага нь дараах шаардлагыг хангасан SMS-ийн зааврыг боловсруулж, байгууллагын гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны мэдээлэл үнэн зөв байхаар зохих нэмэлт өөрчлөлтийг хийдэг байна:

(i) аюулгүй байдлын бодлого, зорилт, нөөц;

(ii) SMS-ийн шаардлага;

(iii) SMS-ийн үйл явц болон журам;

(iv) SMS-ийн үйл явц болон журмаар хүлээх хариуцлага, үүрэг болон олгогдох эрх.

(2) байгууллага нь SMS-ийн баримт бичгийн нэг хэсэг болох SMS-ийн үйл ажиллагааны бүртгэлийг боловсруулж, хөтлөх үүрэгтэй. Байгууллагын үйл ажиллагааны төрөл болон цар хүрээнээс хамааран, SMS-ийн заавар болон SMS-ийн үйл ажиллагааны бүртгэл нь тусдаа

баримт бичиг байдлаар, эсхүл тухайн байгууллагын бусад баримт бичигт нэгтгэсэн байж болно.

100.7. Аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

(а) Аюулыг таньж тогтоох:

(1) байгууллага нь нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээтэй холбоотой аюулыг таньж тогтоох үйл явцыг боловсруулж, хадгална;

(2) аюулыг таньж тогтоох нь хариу арга хэмжээ авах болон аюулаас урьдчилан сэргийлэх аргуудын хослолд суурилсан байна.

(б) Аюулгүй байдлын эрсдэлд үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах:

(1) байгууллага нь илэрсэн аюултай холбоотой аюулгүй байдлын эрсдэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх болон хяналт тавих журмыг боловсруулж, хадгална. Тухайн үйл явц нь аюулгүй байдлын өгөгдлийн дүн шинжилгээний Урьдчилан харах (predictive) аргыг багтааж болно.

100.9. Аюулгүй байдлын баталгаажуулалт

(а) Аюулгүй байдлын гүйцэтгэлийн хяналт болон хэмжилт:

(1) байгууллага нь аюулгүй байдлын гүйцэтгэлийг баталгаажуулах, аюулгүй байдлын эрсдэлийг хянах арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байгааг үнэлэх аргачлалыг боловсруулж, хадгална;

(2) байгууллага нь SMS-ийн хүрээнд дотоод аудит хийх болон тогтмол хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагааг хамарсан чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;

(3) байгууллага нь иргэний нисэхийн холбогдох дүрмээр шаардсан удирдах ажилтнуудаас бүрдсэн Аюулгүй байдлын зөвлөлийг дараах зорилгоор байгуулсан байна:

(i) залруулагдаагүй аудитын үл нийцэлд дүгнэлт хийх;

(ii) залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний саатал, түүний бодит шалтгааныг тодорхойлох;

(iii) аудитын журам, төлөвлөгөө болон давтамжид өөрчлөлт оруулах.

(4) байгууллагын аюулгүй байдлын зорилтыг хэрэгжүүлэх үүднээс аюулгүй байдлын гүйцэтгэлийг SMS-ийн гүйцэтгэлийн үзүүлэлт болон гүйцэтгэлийн зорилттой харьцуулж, Аюулгүй байдлын зөвлөлөөр баталгаажуулдаг байна.

(б) Өөрчлөлтийн удирдлага:

(1) байгууллага нь нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээтэй холбоотой аюулгүй байдлын эрсдэлийн түвшинд гарч болох аливаа өөрчлөлтийг таньж тогтоох бөгөөд тухайн өөрчлөлтөөс үүдэн гарч болзошгүй аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг удирдах үйл явцыг боловсруулж, хадгална.

(с) SMS-ийн байнгын сайжруулалт:

(1) байгууллага нь SMS-ийн үр дүнтэй байдлыг хадгалах, байнга сайжруулах зорилгоор өөрийн SMS-ийн үйл явцад хяналт болон үнэлгээ хийсэн байна.

100.11. Аюулгүй байдлын сурталчилгаа

(а) Сургалт болон боловсрол:

(1) байгууллага нь ажилтан бүрийг SMS-ийн хүрээнд хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх ур чадвартай болохыг бататгах зорилгоор аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

(2) аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ нь ажилтан бүрийн SMS-ны хүрээнд хүлээх үүрэг хариуцлагад тохирсон байна.

(b) Аюулгүй байдлын мэдээлэл солилцоо:

(1) байгууллага нь дараах шаардлага хангасан аюулгүй байдлын мэдээлэл солилцооны тогтсон арга хэлбэрийг боловсруулж, хадгална:

(i) ажилтнууд нь SMS-ийн дагуу хүлээх үүрэг, хариуцлагатай танилцаж, зохих мэдлэг эзэмшсэн болохыг бататгах;

(ii) аюулгүй байдлын чухал мэдээллийг заавал дамжуулдаг байх;

(iii) аюулгүй байдлыг сайжруулахтай холбогдсон авч хэрэгжүүлэх арга хэмжээг, эсхүл өөрчлөх талаар холбогдох санал гаргадаг байх;

(iv) аюулгүй байдлын баримт бичиг, тэдгээрт оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийн санал гаргадаг байх.

100.13. Аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл, эх сурвалжийг хамгаалах

(а) Байгууллага нь аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах үүрэгтэй.

(b) Байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хадгалах, сайжруулах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “ИНЕГ” гэх)-ын хяналтын тогтолцоондоо ашиглах Аюулгүй байдлын өгөгдөл цуглуулах, боловсруулах систем (Safety Data Processing System)-д шаардлагатай өгөгдөл, мэдээллийг дамжуулах үүрэгтэй.

(c) Конвенцын Хавсралт 13-ын дагуу агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлсэн тохиолдолд, тус Хавсралтын 5.12-т заасан осол, зөрчилтэй холбоотой баримт бичгийг иргэний нисэхийн тухай хуулийн хүрээнд хамгаалах үүрэгтэй.

(d) Аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл, эх сурвалжийг хамгаалах үйл ажиллагааг дараах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ:

(1) Ерөнхий зарчим: Байгууллага нь хууль, дүрэм болон бодлогоор аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах талаар дараах шаардлагыг хангасан байна:

(i) нисэхийн аюулгүй байдлыг хадгалах, сайжруулах зорилгоор аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах шаардлагыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалттай уялдуулах;

(ii) аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах шаардлагатай нөхцөл байдлыг тодорхойлох;

(iii) нисэхийн аюулгүй байдлыг хадгалах, сайжруулах зорилгоор аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл нь хүртээмжтэй байх;

(iv) аюулгүй байдлын эерэг соёлыг бий болгох зорилгоор ажилтны сургалт хангалтгүйгээс шалтгаалсан аливаа үйлдэл, эсхүл эс үйлдэлд шийтгэл оногдуулахгүй байх.

(2) Хамгаалалтын зарчим:

(i) байгууллага нь аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг дараах зорилгоор ашигладаггүй болохыг бататгана:

(А) ажилтан, эсхүл байгууллагын эсрэг аливаа хариуцлагын арга хэмжээ авах, эсхүл иргэний, захиргааны болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх; эсхүл

(В) олон нийтэд ил болгох; эсхүл

(С) аюулгүй байдлыг хадгалах, сайжруулахаас бусад зорилгоор.

(ii) байгууллага нь аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг дараах байдлаар хамгаалдаг болохыг бататгана:

(А) аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийн шинж чанараас хамаарч хамгаалдаг байх;

(В) аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах зохицуулалтыг бүрдүүлсэн байх. Аливаа этгээд нь аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг ил болгох үндэслэл бүхий хүсэлт гаргах зохицуулалтыг тусгасан байх;

(С) энэ зүйлийн (d)(3)-т заасан зарчмаас бусад тохиолдолд аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг өөр зориулалтаар ашиглахгүй байх;

(D) аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг энэ зүйлийн (d)(3)-ийн дагуу иргэний, захиргааны, эсхүл эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагаанд ашиглах тохиолдолд зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хийгдсэн байх.

(iii) байгууллага нь ажлын байранд хийсэн аудио болон видео бичлэгийн хамгаалалт, түүний нууцлалыг хангах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрдүүлнэ.

(3) Үл хамаарах зарчим: Аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл болон эх сурвалжийг хамгаалах тухай энэ зүйлийн (d)(2)-т заасан зарчим нь эрх бүхий байгууллагаас тогтоосны дагуу дараах нөхцөлд үйлчлэхгүй:

(i) хайхрамжгүй байдал, санаатай, эсхүл гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдлийг нотлох баримтаар тогтоосон тохиолдолд;

(ii) аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр, тухайн мэдээллийг ил болгох нь хуулийг шударгаар хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд түүний үр нөлөө нь цаашид аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг цуглуулах, ашиглахад учирч болзошгүй дотоод болон олон улсын сөрөг нөлөөнөөс давуу гэж тогтоосон тохиолдолд; эсхүл

(iii) аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр, тухайн мэдээллийг ил болгох нь аюулгүй байдлыг хадгалах, сайжруулахад шаардлагатай бөгөөд түүний үр нөлөө нь цаашид аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг цуглуулах, ашиглахад учирч болзошгүй дотоод болон олон улсын сөрөг нөлөөнөөс давуу гэж үзсэн тохиолдолд;

(iv) аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг ил болгох шийдвэр гаргахад мэдээллийн эх сурвалжийн зөвшөөрлийг харгалзан үзсэн байх;

(v) эрх бүхий байгууллагад шүүхийн байгууллага болон ИНЕГ хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

(4) Олон нийтэд ил болгох. Сайн дураар мэдээлсэн аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийн байнгын нууцлалыг бататгах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) тухайн мэдээллийг олон нийтэд ил болгохоор гаргасан хүсэлтэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу үл хамаарч болох нөхцөлийг тогтооно. Энэ зүйлийн (d)(3)-ын дагуу мэдээллийг ил болгосон тохиолдолд Дарга дараах нөхцөлийг харгалзана:

(i) аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээлэлд багтсан хүний хувийн мэдээллийг олон нийтэд ил болгохдоо Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баримтлах; эсхүл

(ii) аюулгүй байдлын өгөгдөл болон мэдээллийг олон нийтэд ил болгохдоо танигдах боломжгүй байхаар хураангуй, эсхүл товч хэлбэрээр гаргадаг байх.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар А/280

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад иргэний агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, нислэгт тэнцэх чадварын удирдамж гаргах, техникийн үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтоох үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл”-ийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар, “ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар, “ИНД-26 Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “ИНД-43 Техникийн үйлчилгээний ерөнхий дүрэм”-ийг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 1 болон 2 дугаар хавсралт, мөн тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-3 “Агаарын хөлөг, түүний эд ангиудын үйлчилгээ засварын газар, нисэхийн үйлчилгээний байгууллагад үзлэг, шалгалт хийх, тэдгээрт нэвтрэх”-ийн “ИНД-43 Техник үйлчилгээний ерөнхий дүрэм”, 15 дугаар хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-15 “Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөгт дуу чимээний хязгаарлалт тогтоох”-ын “ИНД-26 Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага”-ыг тус тус бүхэлд нь, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/311 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны “Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/273 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433946625532>

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 7415 дугаарт бүртгэв.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/383, А/112

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /Бригадын генерал Т.Сүхболд/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Журам батлах тухай” 468, А/268 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙД

Ч.УНДРАМ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/383, А/112 дугаар хамтарсан тушаалын хавсралт

СПОРТ-СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум эзэмших, хадгалах харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд бол байгууллагын дарга нь галт зэвсэг, сумны хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

1.3.Галт зэвсэг, сумыг зориулалтын бусаар ашиглах, хадгалах, олгох, шаардлагагүй үед сумны байранд сум оруулах, гох дарах, бэхэлгээ болон хамгаалалтгүй саванд ил орхих, зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.

Хоёр.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд галт зэвсэг эзэмших

2.1.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгээ Галт зэвсгийн тухай хуулийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу бүртгүүлнэ.

2.2.Спорт-сургалтын зориулалтаар эзэмших галт зэвсгийг зориулалтын дагуу хувь хүнд хариуцуулан буудлага хийлгэж болно.

2.3.Спорт-сургалтад суралцагч, тамирчид нь зөвхөн багш, дасгалжуулагч, зааварлагчийн хяналт, удирдлага дор галт зэвсэг ашиглана.

2.4.Галт зэвсгийг ашиглах, хэрэглэхийн өмнө хариуцсан багш, дасгалжуулагч, зааварлагч нь тамирчин, суралцагчид осол, аюулгүйн ажиллагааны зааварчилга өгч, гарын үсэг зуруулна.

2.5.Тамирчин, суралцагч нь хариуцсан сум, галт зэвсэгтэй осол, аюулгүй ажиллагааны зааварчилгын дагуу харьцаж буудлага үйлдэнэ.

2.6.Спорт-сургалтын буудлагыг шаардлага хангасан буудлага үйлдэх байгууламж /тир/-д хийнэ.

2.7.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь галт зэвсэг, сум ашигласан, буудлага үйлдсэн тухай бүртгэл, галт зэвсэг, сум, галт хэрэгсэл хүлээлгэн өгөх тооцооны хуудастай байна.

2.8.Спорт-сургалтын зориулалтаар эзэмших галт зэвсгийг авч явах, тээвэрлэхэд Галт зэвсгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангана.

2.9.Спорт-сургалтын зориулалтаар эзэмших галт зэвсгийг үйлдвэрийн зориулалттайгаас бусад эд ангиар солихыг хориглоно.

2.10.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь өөрийн өмчилж, эзэшиж байгаа галт зэвсэг, сумны тооллогыг сар бүр явуулж, бүрэн бүтэн байдалд нь хяналт тавина.

Гурав.Галт зэвсэг, сум хадгалах

3.1.Галт зэвсэг, сумыг Галт зэвсгийн тухай хуулийн 14.6 дахь хэсэгт заасны дагуу аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглогсон зориулалтын агуулахад галт зэвсгийг сумнаас тусад нь зориулалтын шүүгээ /сав/-нд хадгална.

3.2.Энэ журмын 3.1-д заасан агуулах нь гадны нөлөөлөл, халдлагаас хамгаалагдсан, харуул хамгаалалтын болон галын систем, дохиолол, хяналтын телекамераар тоноглогдсон байна. Дохиолол, теле-хяналтын систем нь байгууллагын жижүүрийн хяналтад байна.

3.3.Галт зэвсэг, сумны агуулах, өрөө /сейф/-ний түлхүүрийг төмөр хайрцагт хийж, зэвсэг хариуцсан албан тушаалтан лацдаж, жижүүрт хадгалуулна. Жижүүр нь зэвсгийн өрөө /сейф/-ний лац хүлээн авсан, хүлээлгэн өгсөн бүртгэлийн дэвтрийг өдөр тутам хөтөлнө.

3.4.Галт зэвсэг, сум хадгалах агуулахын хаалга нь төмөр болон галд шатдаггүй материалаар хийгдсэн, давхар хаалга, лацтай байна.

3.5.Агуулах нь цонхгүй байх ба жижиг салхивчтай байж болно. Салхивчтай бол дотор, гадна талаасаа төмөр хийцийн тороор хамгаалагдсан байна.

3.6.Галт зэвсгийг тусгай зориулсан тавиур дээр тоолж болохуйц эмх цэгцтэй байрлуулж гох, замаг эсвэл хайрцагийг цоожилж хадгална.

3.7.Галт зэвсэг хадгалах агуулах, складны гадна буюу эргэн тойронд тэсэрч дэлбэрэх, галд шатамхай аюултай бодисыг байрлуулахыг хориглоно.

Дөрөв.Бусад

4.1.Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгээ жил бүр галт зэвсгийн тооллогод хамруулна.

4.2.Спорт-сургалтын галт зэвсэг, түүний эд анги, сумыг алдаж үрэгдүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 7416 дугаарт бүртгэв.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/384, А/113

Улаанбаатар
хот

БУУДЛАГА ҮЙЛДЭХ БАЙГУУЛАМЖ /ТИР/-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ

Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Спорт-сургалтын зориулалтаар ашиглах буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлагыг нэгдүгээр, Галт зэвсэг, сум худалдах төвийн буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын 1-д заасан шаардлагыг хангаж ажиллахыг спорт-сургалтын болон галт зэвсэг, сум худалдах төвийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /Бригадын генерал Т.Сүхболд/-д тус тус даалгасугай.

3 Энэ тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага батлах тухай” 433, А/248 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙД

Ч.УНДРАМ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

*Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хууль зүй, дотоод
хэргийн сайдын 2025 оны А/384, А/113 дугаар хамтарсан тушаалын
1 дүгээр хавсралт*

СПОРТ-СУРГАЛТЫН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ БУУДЛАГА ҮЙЛДЭХ БАЙГУУЛАМЖ /ТИР/-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг.Нийтлэг зүйл

1.1."Буудлага үйлдэх байгууламж /тир/" гэж Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.5-д заасныг ойлгоно.

1.2.Тирийг 3 ангилна:

1.2.1.Битүү;

1.2.2.Хагас битүү;

1.2.3.Задгай.

Хоёр.Ерөнхий шаардлага

2.1.Битүү, хагас битүү, задгай тир нь тухайн буудлагын зэвсэг, суманд тохирсон аюулгүй байдлыг хангасан хаалт баригчтай байна.

2.2.Буудлагын тир талбай нь олон тооны буудагчид зориулсан төрөл бүрийн зай, талбайтай байж болно.

2.3.Буудлагын тир болон зэвсэг хадгалах өрөө нь нэг барилгад байгаа тохиолдолд бусад төрлийн туслах өрөө тасалгаануудаас тусдаа байна.

2.4.Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сантай байна.

2.5.Тирний шаардлага хангасан эсэхэд спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргаж, цагдаагийн байгууллага хяналт тавина.

Гурав.Битүү тирэнд тавигдах шаардлага

3.1.Хана, тааз, шалыг сум нэвтрэхээргүй материалаар бэхжүүлэн баригдсан барилга бүхий байгууламж байна.

3.2.Хана тааз шал нь үндсэн барилгын хийцтэй, чулуун болон тоосгон өрлөгний зузаан нь 360 мм-ээс багагүй, ханын бетонон блокны зузаан нь 200 мм-ээс багагүй хоёр үе өрлөгтэй буюу нийт 400 мм-ээс багагүй байна. Төмөр бетон хавтантай бол 180 мм-ээс багагүй зузаантай байна. Дээрх материалыг чанарын хувьд давуу материалаар орлуулан хийж болно. Мөн ханын дагуу сум баригч болон сум хүлээн авагч хийж болно.

3.3.Битүү тир нь хот суурин газарт байрлаж болно.

Дөрөв.Хагас битүү тирэнд тавигдах шаардлага

4.1.Хана нь сум үл нэвтрэх материалаар хийгдсэн, буудагчийн хэвтээ байрлалаас тэнгэр харагдахааргүй хөндлөн сум баригч ханатай байна. Хагас битүү тирэнд нэмэлт сум баригч байрлуулж болно.

4.2.Хагас битүү тир нь барилга, байгууламж, нийтийн орон сууцаас нүүрэн талаасаа 100 метрээс багагүй, бусад талаасаа 300 метрээс багагүй зайд байрлана.

Тав.Задгай тирэнд тавигдах шаардлага

5.1.Сум үл нэвтрэх шороон далан бүхий бүтэцтэй, аль эсвэл материалын бүтцийн хувьд сум эргэн ойхооргүй, нэвтрэхээргүй далан /хаалт/ нь 2,5 метрээс багагүй өндөртэй байна. Шороон далан нь 3 талыг хаасан байна.

5.2.Аюулгүйн бүс, анхааруулах тэмдэг /буудлагын тир/ гэсэн тэмдэглэгээтэй байна.

5.3.Задгай тир нь буудах чиглэлдээ суурин газраас 3000 метрээс багагүй зайтай байрлана. Задгай тирний буудах чиглэлд байгалийн хаалт, саад байгаа, эсхүл буудлагын спортын төрөл нь хамгийн холдоо 300 метр бууддаг бол газар зүйн онцлогоос хамаарч суурин газраас 1000 метрээс багагүй тогтоож болно.

5.4.Холын буудлага буудах задгай тирийн аюулгүйн бүсийг түүний хамгийн хол буудах зайнаас цааш 1000 метрээс багагүй тогтоож болно.

5.5.Тирийн буудах чиглэлээс бусад чиглэлд суурин газраас 500 метрээс багагүй зайтай байх бөгөөд нүүрэн хэсэг нь далантай байж болно.

5.6.Таваг буудлагын спортын задгай тир нь суурин газраас 300 м-ээс багагүй зайд байрлана.

5.7.Энэ шаардлагын 5.3 дахь заалтад заасан нүүрэн хэсгийн далангийн өндөр 2.5 доошгүй бол 300 метрээс, 5 метрээс доошгүй бол 200 метрээс багагүй, эсхүл нийтэд үйлчлэх зориулалт бүхий барилга байгууламжтай бол тухайн хэсгээрээ 100 метрээс доошгүй зайд тус тус байрлаж болно.

*Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хууль зүй, дотоод
хэргийн сайдын 2025 оны А/384, А/113 дугаар хамтарсан тушаалын
2 дугаар хавсралт*

ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ ХУДАЛДАХ ТӨВИЙН БУУДЛАГА ҮЙЛДЭХ БАЙГУУЛАМЖ /ТИР/-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Галт зэвсэг, сум худалдах төв нь битүү тиртэй байна.
2. Хана тааз шал нь сум нэвтрэхээргүй материалаар бэхжүүлэн баригдсан үндсэн барилгын хийцтэй, чулуун болон тоосгон өрлөгний зузаан нь 360 мм-ээс багагүй, ханын бетонон блокны зузаан нь 200 мм-ээс багагүй хоёр үе өрлөгтэй буюу нийт 400 мм-ээс багагүй байна. Төмөр бетон хавтантай бол 180 мм-ээс багагүй зузаантай байна. Дээрх материалыг чанарын хувьд давуу материалаар орлуулан хийж болно. Мөн ханын дагуу сум баригч болон сум хүлээн авагч хийж болно.
3. Зэвсэг, сум, хэрэгсэл хадгалах өрөө, тасалгааны хамгаалалт бэхэлгээний хийцийн далд болон ил бүтээцийн ажлын актыг хөтөлсөн байна.
4. Агааржуулалтын хоолой болон бусад инженерийн шугам сүлжээний нүхийг 50х50 мм-ийн хэмжээтэй торлог бүтэцтэй 16 мм-ээс багагүй огтлол бүхий арматураар бэхэлнэ.
5. Стандарт дүрмийн дагуу галын аюулаас хамгаалах тоног хэрэгсэлтэй, дохиолол хамгаалалтын системтэй байна.
6. Буудлагын тир болон зэвсэг хадгалах өрөө нь бусад өрөө тасалгаануудаас тусдаа байрлана.
7. Буудлагын тир нь галт зэвсэг, суманд тохирсон аюулгүй байдлыг хангасан хаалт баригчтай байна.
8. Буудлагын тирний сумны нисэлтийн талбайн урт нь 50 м-ээс доошгүй байна.
9. Буудлагын тир нь галт зэвсгийн ажиллагааг шалгахад зориулсан зай, талбай, төхөөрөмжтэй, зориулалтын суурь, тавиуртай, аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий зааварлагч-ажилтантай байна.
10. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сантай байна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 7417 дугаарт бүртгэв.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар А/385, А/114, А/831

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ БОЛОН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АНГИЛАЛД
ХАМААРАХ ГАЛТ ЗЭВСЭГ, СУМНЫ НЭР, ТӨРЛИЙН ЖАГСААЛТ
БАТЛАХ ТУХАЙ**

Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг
үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт
зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн
ерөнхий газрын дарга /Бригадын генерал Т.Сүхболд/-д даалгасугай.

3.Энэ тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн
бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д
нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын
сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн
“Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг,
сумны нэр, төрлийн жагсаалт батлах тухай” А/250, А/379, 437 дугаар
хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

Б.БАТБААТАР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙД

Ч.УНДРАМ

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/385, А/114, А/831 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

1.ИРГЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ

№	ГАЛТ ЗЭВСГИЙН АНГИЛАЛ	СУМНЫ АНГИЛАЛ
1.1.АН АГНАХ		
1	Ажиллагааны хувьд гараар цэнэглэгдэх, хүхээгтээ нэг, дайзанд 5-аас илүүгүй сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй 4,5 мм-ээс 12,7 мм хүртэлх калибрийн галт зэвсгүүд; /Мосин-нагант, маузер болон түүнтэй ижил төстэй замагны түгжилттэй галт зэвсгүүдийг ойлгоно/	Тусгай зориулалттайгаас бусад 4,5 мм-ээс 12,7 мм хүртэлх калибрийн, хошуу нь зүрхэвчгүй бүх төрлийн ангийн зориулалттай сум;
2	Гөлгөр гол төмөртэй гараар цэнэглэгдэх, хүхээгтээ нэг, дайзанд 5-аас илүүгүй сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй галт зэвсгүүд;	Гөлгөр гол төмөрт зориулагдсан бүх төрлийн ангийн сум;
1.2.СПОРТ-СУРГАЛТЫН		
1	Хуульд өөрөөр заагаагүй бол ажиллагааны хувьд автоматаар буудах боломжгүй, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй, олон улсын спорт холбоодын дүрмээр зөвшөөрөгдсөн эсвэл үйлдвэрлэгчийн тодорхойлолттой галт зэвсгүүдийг ойлгоно. /Автоматаар буудах гэдгийг гохон дээрх нэг удаагийн даралтаар 2 ба түүнээс дээш тооны сум гаргахыг ойлгоно/	Тусгай зориулалттайгаас бусад 4,5 мм-ээс 12,7 мм хүртэлх калибрийн, сумны хошуу нь зүрхэвчгүй бүх төрлийн сум;
2	Гөлгөр гол төмөртэй ажиллагааны хувьд автоматаар буудах боломжгүй, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй галт зэвсгүүд;	Гөлгөр гол төмөрт зориулагдсан бүх төрлийн сум;
1.3.ҮЗМЭР, ЦУГЛУУЛГЫН		
1	Түүхэн, ховор, үнэт, дурсгалтай, холбогдох байгууллага болон гарал үүсэл, эх сурвалжийн тодорхойлолттой бүх төрлийн галт зэвсгүүд	Тусгай зориулалттайгаас бусад хошуу нь зүрхэвчгүй бүх төрлийн сум

2.ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЛТ ЗЭВСЭГ, СУМ

1	Хуульд өөрөөр заагаагүй бол ажиллагааны хувьд автоматаар буудах боломжгүй, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй 5,6 мм-ээс 9 мм хүртэлх калибрийн галт зэвсгүүдийг ойлгоно.	Тусгай зориулалттайгаас бусад 5,6 мм-ээс 9 мм хүртэлх калибрийн, сумны хошуу нь зүрхэвчгүй бүх төрлийн сум;
---	--	---

2	Гөлгөр гол төмөртэй ажиллагааны хувьд автоматаар /гохон дээрх нэг удаагийн даралтаар 2 ба түүнээс дээш тооны сум гаргахгүй/ буудах боломжгүй, үйлдвэрийн хийцийг өөрчлөөгүй галт зэвсгүүд;	Гөлгөр гол төмөрт зориулагдсан бүх төрлийн сум;
---	--	---

3.Галт зэвсгийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цагдаагийн байгууллагад ан агнах, спорт-сургалт, цуглуулга, үзмэрийн зориулалтаар бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авсан бол иргэний, харуул хамгаалалтын зориулалтаар бүртгүүлж гэрчилгээ авсан бол харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг гэж үзнэ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/97

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” Хууль зүйн сайдын 2014 оны А/190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“2.1. Орон нутгийн малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн алдуул болон хулгайлагдсан малын талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгч, харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллана.”

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (А.Энх-Эрдэнэ)-д даалгасугай.

САЙД

Л.МӨНХБААТАР

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авсан.*

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/98

Улаанбаатар
хот

ТУШААЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2014 оны А/90 дүгээр тушаалын үндэслэх хэсгийн “41.12 дахь хэсгийг” гэснийг “41.13 дахь хэсгийг” гэж, мөн тушаалын 2 дахь хэсгийн “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар /Б.Пүрэвдорж/” гэснийг “Гадаадын иргэн, харьяатын газар /Н.Ууганбаяр/” гэж тус тус өөрчилсүгэй.

САЙД

Л.МӨНХБААТАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/99

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Галт зэсгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам батлах тухай” Хууль зүйн сайдын 2015 оны А/219 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“4.1.1.Галт зэвсэг, сум, гал зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах тухай ажлын хэсгийн шийдвэрийг “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”-ын 2.1-т заасан харьяа нутаг дэвсгэрийнхээ Засаг даргын дэргэдэх орон тооны бус захиргааны Зөвлөл /цаашид “Захиргааны зөвлөл” гэх/-д хүргүүлж, танилцуулна.”

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга (Т.Сүхболд)-д даалгасугай.

САЙД

Л.МӨНХБААТАР